



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 4/02

Улаангом

Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл
ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын "д", 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 17 дугаар зүйлийн 17.1, 17.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүй, дотоод хяналтын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Увс аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", түүний хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэгдүгээр хавсралтаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн саналыг тусгасан хөрөнгө оруулалтын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аймгийн Засаг дарга М.Чимэд/-д даалгах нь:
 - 2.1. "Увс аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох хөгжлийн баримт бичгүүдтэй уялдуулан шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгаж төлөвлөн хэрэгжүүлэх
 - 2.2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж байх
 - 2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх явц, үр дүнг тухай бүр тооцож, хүрсэн түвшинг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж бай
 - 2.4. Хөтөлбөрийн биелэлтийн явц, хүрсэн түвшинг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх

3. Сумдын засаг дарга нарт даалгах нь:

3.1. "Увс аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдох ажлыг сумынхаа дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган баталж, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тооцон, аймгийн Засаг даргын тамгын газарт тайлагнах.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Дамдинсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТБОЛД

Аймгийн ИТХ-ын 2021 оны 03 сарын 06-ны
өдрийн 4 дүгээр хуралдааны 4/02 тоот
тогтоолыг нэгдүгээр хавсралт



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Энэхүү хөтөлбөрийг Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан.

Аймгийн эдийн засаг, нийгэм соёлын онцлог, эрчим хүчний нөөцөд тулгуурласан, уламжлалт ахуй, шинэ технологи инноваци бүхий Хөдөө аж ахуй-Аялал жуулчлалыг хөгжүүлсэн “ОРЛОГЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-УВС” зорилтыг дэвшүүлж байна.

НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилт 1.1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, аймаг, орон нутгийн хэмжээнд цаг алдалгүй шуурхай зохион байгуулна.

- 1.1.1. Цар тахлын хатуу хорио цээрийн улмаас иргэд, өрх айл, аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээ, бизнес эрхлэгчдэд учирч буй хүндрэл бэрхшээлийг судлан тогтоож орон нутгийн түвшинд шийдвэрлэх боломжтой арга хэмжээг авах
- 1.1.2. Энэ чиглэлд гарсан Засгийн газрын бодлого шийдвэр болон вакцинжуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулж хэрэгжүүлэх
- 1.1.3. Онцгой нөхцөлд ажиллах төрийн албан хаагчид, эмч мэргэжилтний нөөц, бие хамгаалах хэрэгсэл, шаардлагатай материалыг бэлтгэх, хэрэгцээт хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, түргэвчилсэн болон PCR оношлогооны орчинг бүрдүүлэх,
- 1.1.4. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлэх чиглэлээр УИХ-ын гишүүд, хөгжлийн түншүүд, олон улсын байгууллагуудтай хамтрах
- 1.1.5. Бусад арга хэмжээ, онцгой байдлын онцлог үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээлэл түгээх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг байнга хангаж ажиллах
- 1.1.6. Олон нийтийн оролцоот хөтөлбөр “ОНОХ” төслийг хэрэгжүүлэх

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Боловсрол

Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ:

- 2.1.1. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, 5 сургуулийн барилгыг шинээр барих, 5 сургуулийн барилгыг засварлах, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, 5 дотуур байранд засвар хийх, 8 цэцэрлэгийн шинэ барилга, өргөтгөл барих

2.1.2. Сургуулийн лабораторийн тоног төхөөрөмж, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл, тоглоомыг шинэчлэх, сургуулийн номын сангийн фондыг баяжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

2.1.3. Таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах, ясли, хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлнэ.

2.1.4. Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, халуун ус, угаалгын үйлчилгээ, номын сан, чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхэд хөгжлийн танхим, тоглоомын өрөөтэй болгох, малчдын 6 настай хүүхдийг сургуульд дасан зохицоход дэмжлэгт орчин бүрдүүлэх

Багш, ажилтны хөгжил, нийгмийн баталгааг хангаж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар боловсролын байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

2.1.5. Багшийн ёс зүй, нэр хүнд үнэлэмжийг дээшлүүлэх, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн “Чадварлаг багш” арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх

2.1.6. Улсын олимпиадад оролцох багш, сурагчдын зардалд дэмжлэг үзүүлэх, улсын олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалт, хүүхэд бүрийг хөгжихөд онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулахад төр, олон нийтийн оролцоог хангах

2.1.7. Төрөлжсөн ахлах сургуулиудыг байгуулах, тэдгээр сургуулиудыг багшлах боловсон хүчин, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах

Насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд:

2.1.8. “Насан туршийн боловсролын төв”-ийн сургалтын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

2.1.9. Насан туршийн боловсрол олгох хөтөлбөрүүдээр зайны сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх

2.1.10. Мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, эрэлт, хөгжилд нийцүүлэн хөгжүүлж, орон нутагт мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагуудыг боловсон хүчин, сургалтын тоног төхөөрөмжөөр хангах

2.1.11. Хүүхдийн хөгжил, оролцоо, хүүхдийн хамтын үүсгэл санаачлагын идэвхийг дэмжих

2.1.12. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх

2.1.13. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, гудамж талбай, гэр хороолол, үйлдвэрийн бүтээгдэхүүний хаяг, шошгыг монгол бичгээр гаргаж хэвшүүлэх

2.1.14. Хөдөөгийн багийн төвүүдийг түшиглэн, насан туршийн боловсролын төв болгон хөгжүүлэх

2.1.15. “Хүн болох багаасаа” арга хэмжээг өрх гэр, сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд хэрэгжүүлж, зөв хандлагыг төлөвшүүлэх

2.1.16. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж, тусгай хэрэгцээт сургалтын орчинг бүрдүүлнэ.

Зорилт 2.2. Үндэсний ёс заншил, язгуур урлагаа хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж нийгмийг соён гэгээрүүлнэ.

- 2.2.1. Соёлын биет болон биет бус өвийн шавь сургалтыг зохион байгуулах, өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх, язгуур өв соёлыг нэр төрлөөр нь хөхиүлэн дэмжих, олон нийтэд түгээн сурталчлах
- 2.2.2. Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүүхэд, залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн номоор фондын баяжилтыг нэмэгдүүлэх, утга, уран зохиолыг дэмжих, номын баярыг жил бүр зохион байгуулах
- 2.2.3. Соёл урлагийн байгууллагын боловсон хүчнийг үе шаттай бэлтгэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хөгжүүлэх
- 2.2.4. Аймгийн хөгжимт жүжгийн "Ойрад" театрын шинэ барилгыг ашиглах шинэ менежмент, маркетингийг хэрэгжүүлж, олон улсын жишигт хүргэх
- 2.2.5. Язгуур өв соёлоо гадаад, дотоодод сурталчлан дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж, уран бүтээлчдийн галарей үйл ажиллагааг дэмжих
- 2.2.6. Хилийн цэргийн ... дугаар ангийн соёлын төвийн барилгын өргөтгөл барих, соёл, урлагийн байгууллагын хөгжим, техник хэрэгслэлийн хангалтыг үе шаттай шинэчлэх
- 2.2.7. Аймгийн төв музейг стандартад нийцсэн шинэ байртай болгох, музейн боловсролын үйлчилгээг өргөжүүлэн, олон нийтэд сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах
- 2.2.8. Баруун монгол түмний баатарлаг туулийг Цагаан сараар хайлдаг арга хэмжээг жил бүр зохион байгуулах, сум, орон нутгийн үндэсний соёл урлагийг сэргээж, сумдад онцлог, бусдаас ялгарах язгуур өв, брэнд арга хэмжээнүүдийг төрт ёсны үндэсний баяр наадмаар бүсчлэн зохион байгуулж, сурталчлах
- 2.2.9. Соёлын биет бус өв болох туульч, ерөөлч, магтаалч, хөөмийч, биелээчдийн улс бүсийн, олон улсын фестиваль, наадам, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулах
- 2.2.10. Увс нутгаас гаралтай түүхэн хүмүүсийн тухай, угсаатны зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулж, баримтат кино хийх, үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчилан таниулах
- 2.2.11. Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа Увс аймгийн нутаг дэвсгэрээс олдсон түүх соёлын хөдлөх дурсгалыг аймгийн музейд төвлөрүүлэх, соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэн баримтжуулах, тооллого хийх ажлыг зохион байгуулах

Эрүүл мэнд

Зорилт 2.3. Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, хариуцлагатай, хүртээмжтэй, үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно.

- 2.3.1. Эрүүл мэндийн төвүүдийн засвар, өргөтгөлийн ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- 2.3.2. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангаж, авто машины парк шинэчлэлтийг хийх
- 2.3.3. Аймгийн нэгдсэн эмнэлгийн зөвлөх поликлиникийн байрыг шинээр барих ажлыг эхлүүлэх
- 2.3.4. Засгийн газрын эрүүл мэндийн зорилтот арга хэмжээнүүдийг төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах, зайн оношлогооны чадавхийг дээшлүүлэх

2.3.5. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх

2.3.6. Бүх нийтийн эрүүл мэнд, соёл, ахуйн үйлчилгээний цогц үйлчилгээг иргэдэд хүргэх зорилтот арга хэмжээг зохион байгуулах

2.3.7. Жирэмсэн эхийн эрт үеийн хяналтын чанарыг сайжруулж, хожуу хүндрэлийг бууруулах, нялхсын золгүй, гэнэтийн нас баралт, эндэгдлийг үе шаттайгаар бууруулах

2.3.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, гадаад болон дотоодод багаар нь сургах

2.3.9. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт 2.4. Биеийн тамир, спортын чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна:

2.4.1. Усан бассейн, спорт фитнесийн барилгыг ашиглалтанд оруулж, наадмын талбайг тохижуулах

2.4.2. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшил, спортын холбоодын түншлэлийн менежментийг хэрэгжүүлэх, амжилтад суурилсан урамшууллын журмыг мөрдүүлэх

2.4.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх

2.4.4. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжин хөгжүүлэх

2.4.5. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах

Гэр бүл

Зорилт 2.5. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ:

2.5.1. "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж, аюулгүй амар тайван амьдарч аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх

2.5.2. "Хуримтлалтай иргэн" төсөл, бүтэн өнчин хүүхдийн "Хөх толбот" арга хэмжээг хэрэгжүүлэх

2.5.3. Өсвөр үе, хүүхдийн хөгжил, оролцоог хангасан "Тэмүүлэл" зусланг ажиллуулах, хүүхдийн авьяас ур чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, дэмжих

2.5.4. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах, осол гэмтэл хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах

2.5.5. Гэр бүл төлөвлөлт, тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн зэрэг харилцаа, уламжлалт зан заншлын талаарх сургалт, хөгжлийн үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлд мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулах

2.5.6. Өрх бүр угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжих

2.5.7. Нийгмийн сайн сайхны төлөө онцгой амжилт гаргаж, сайн дураараа ажилладаг, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн "Нийгмийн манлайлагч" иргэнийг жил бүр шалгаруулан алдаршуулах

Нийгмийн хамгааллын шинэчлэлийг хэрэгжүүлнэ

Зорилт 2.6. Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.6.1. Иргэд даатгуулагчийн нэрийн дансны хуримтлал үүсгэх нийгмийн даатгалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх

2.6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажлын байрны осол гэмтлээс урьдчилан сэргийлэх

2.6.3. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, хөтөлбөр бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдлийг бууруулж, жилд 1200 ажлын байр бий болгох

2.6.4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын байгууллагуудыг түшиглэн хэрэгцээнд нийцсэн чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэж, ажилд зуучилах

2.6.5. Иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангаж, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах

2.6.6. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, халамжийн үйлчилгээг цахим, ил тод нээлттэй, чирэгдэлгүй болгох

2.6.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих "Тэгш боломж" арга хэмжээ хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан өдөр өнжүүлэх ажиллуулах

2.6.8. Ахмад настны хөгжил хамгааллыг дэмжиж, сумдын ахмадын байгууллагыг бэхжүүлж, ахмадын байр, ахмад настнуудад үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хувийн хэвшлийн оролцоог дэмжих

2.6.9. Жөндөрт суурилсан хүчирхийлэл, жөндөрийн хэвшмэл ойлголт, тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилт 3.1. Аймгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэн тогтоож, ХАА-н боловсруулах болон хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:

3.1.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд технологи суурьтай инновацийг нэвтрүүлж, бүс нутгийн нөөц баялагт түшиглэсэн төр-хувийн хэвшлийн түншлэл, олон улсын байгууллага, олон нийтийн оролцоот хоршооны менежментийг нэвтрүүлэх замаар эдийн засгийн өгөөж, өрхийн орлого, бүтээмж, үнэ цэнэ, баталгаатай ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго бүхий "ШИНЭ ХӨДӨӨ-УВС" төслийг хэрэгжүүлэх

3.1.2. Бүс ба орон нутгийн иргэдийг чанартай экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангах, олон улсын чанар, стандартыг нэвтрүүлсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, орон нутагт шинэ ажлын байр бий болгох хөдөө аж ахуйн "УВС-АГРО" Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлэх

3.1.3. Аймгийн хадлан тариалангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлж, тэжээлийн голлох ургамлууд болох царгас, овъёос, эрдэнэ шиш, гурвалжин будаа тариалж, Баруунтуруун, Тариалан, Улаангом сумуудад "ГУРИЛ-ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭР" байгуулж, аймгийнхаа болон баруун бүсийн хэрэгцээг хангах

- 3.1.4. Аймгийн онцлог шинж чанар, язгуур үнэт зүйл, өв соёл, байгаль, цаг уур, бахархал, орон нутгийн нөөц баялагт тулгуурласан нэгдсэн нэг брэндийн бодлого гарган үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж гадаад, дотоодын зах зээлд сурталчлан таниулах
- 3.1.5. Жуулчдын урсгал, экспортын хэмжээг нэмэгдүүлж, Боршоо олон улсын боомтын "Шалган нэвтрүүлэх цогцолбор"-ын шинэчлэлийг хэрэгжүүлэх
- 3.1.6. Аймагт "Баруун бүсийн тээвэр логистикийн төв" байгуулах
- 3.1.7. "Дэглий цагаан" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын зэрэглэлтэй болгох, зарим сумдад ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх
- 3.1.8. Цахилгаан эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэх хөрөнгө оруулалтын 60 МВт-ын цахилгаан станц барих төслийн ажлыг эхлүүлэх
- 3.1.9. Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, уурхайнуудтай "Хамтран ажиллах гэрээ"-ний хүрээнд үр дүнг тооцож ажиллуулах, тодорхой чиглэлд геологийн хайгуул судалгааг үргэлжлүүлэх
- 3.2.10. Давс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалын боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжих
- 3.1.11. Аймагт үйл ажиллагаа эрхэлдэг төмрийн хүдэр, нүүрсний болон бусад уурхайн үйлдвэрийн ашиг хүртэгч эзэдтэй хамтран, хөрөнгийн хуримтлал бий болгох, орон нутаг, айл өрхийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх

Зорилт 3.2. Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлж, байгаль, эдийн засгийн хөгжлийг хангана.

- 3.2.1. Баруун Монголын өв соёл, байгалийн болон түүх соёлын үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулах, аялал жуулчлалын нөөц баялагт үндэслэн, аялал жуулчлалын шинэ маршрутад тулгуурласан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, түүнийг дагасан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх
- 3.2.2. Архитектурын шинэ шийдэлтэй "СОЁЛ АМРАЛТЫН ТӨВ"-ийг байгуулж, олон төрөлт арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах
- 3.2.3. Аялал жуулчлалын барилга байгууламж, отоглох, амрах цэгүүд байгуулж, сумдад аялал жуулчлалд зориулсан дэд бүтцийг дэмжих
- 3.2.4. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, зан заншил, уламжлал, нүүдэлчин ахуйд түшиглэсэн аялал жуулчлалын "Чингисийн цагаан сүлд цэнгүүлэх", "Ус ба аялал жуулчлал", "Тэмээн жин ба нүүдэл", "Язгуур урлаг", "Ээрэн хүрээ", "Бух ноолдаан", "Увс нуур цом"-ын барилдаан.. гэх мэт бүс нутаг, олон улсыг хамарсан аялал жуулчлалын томоохон бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх
- 3.2.5. Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар стандартын шаардлага хангасан жуулчны баазыг байгуулж, жуулчдын ая тухыг хангах орчныг бүрдүүлэх
- 3.2.6. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах, авто зогсоол, үйлчилгээний төв, ариун цэврийн байгууламжийг байгуулах
- 3.2.7. Хяргас, Увс, Үүрэг нууруудын орчинд хязгаарлах бүс зоон тогтоож тэмдэгжүүлэх, аялал жуулчлалын баазуудыг аттестатчилах, нуур орчмын бүс нутгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр ашиглуулах

Тогтвортой хөдөө аж ахуй

Зорилт 3.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:

3.3.1. Мал аж ахуй, газар тариалангийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, фермерүүд, жижиг дунд үйлдвэрлэгчид болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх

3.3.2. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, бие даасан үүлдрээр батлагдсан Баяд хонь, Өлгийн улаан ямаа, Тэс адуу болон нутгийн шилмэл омгийн үржлийн малаар малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх

3.3.3. Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариалангийн бүс нутгийг тогтоох, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, үр тариа болон голлох нэр төрлийн хүнсний ногоо, чацаргана, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын нутагших чадвартай үр, сортыг бодлогоор хөгжүүлж дотоодын болон бүсийн хэрэгцээг хангах, зэрлэг чацарганыг хамгаалах, бусад ашигт таримлын үйлдвэрлэл, өвөл зуны хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлэх

3.3.4. Дундын хоршоодыг чадавхжуулан, хөдөө аж ахуйн бүтээмж үр ашгийг нэмэгдүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт технологид суурилсан шинэ ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, техник хангамжийг нэмэгдүүлэх

3.3.5. Өртгийн сүлжээ, кластерт холбогдсон бизнес болон ЖДҮ-ийг бодлогоор дэмжих

3.3.6. Малын тоо толгойн татварын орлогыг бэлчээрийн менежмент, даац багтаамж, ашиглалт хамгаалалт, усан хангамж сайжруулахад зарцуулах

3.3.7. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийг барих санаачлагыг дэмжих, малын түүхий эдийг худалдан борлуулах нэг цэгийн үйлчилгээг бий болгох

3.3.8. Бизнес инкубатор төвийг байгуулж, гарааны бизнес эрхлэгчдийг чадавхжуулах

3.3.9. Хүнсний аюулгүй байдлыг хангах асуудалд төр, ТББ, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

3.3.10. Ашиг шимт мах сүүний чиглэлийн үхрийг үржил селекцид оруулж, үхрийнхээ үүлдэр угсааг сайжруулан, тэжээл тариалангийн үйлдвэрлэлийн бүсийг түшиглэн мах, сүүний фермерийн аж ахуйг хөгжүүлэх

Ухаалаг санхүүгийн зах зээл

Зорилт 3.4. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:

3.4.1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн механизмыг ил тод, нээлттэй хэрэгжүүлэх

3.4.2. Дотоод, гадаадын бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, үзэсгэлэн худалдаа, төрөлжсөн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулах, бүс, улс, олон улсын арга хэмжээнд оролцох

3.4.3. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан, дотоодын болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх

3.4.4. Банк санхүү, даатгалын үйлчилгээний мэдээллийг цахимаар түгээх, гарын авлагаар сурталчилах, сургалт зохион байгуулах

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

“Цахим Увс”-төрийн шуурхай үйлчилгээ (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)

Зорилт 4.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, цахим бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

- 4.1.1. “Нэг иргэн-нэг бүртгэл” үйлчилгээг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний стандартыг хангуулах
- 4.1.2. Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн “Ухаалаг Увс” арга хэмжээг хэрэгжүүлэх
- 4.1.3. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар “e-mongolia” системийн хүртээмж, төрийн албан хаагчдын бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх
- 4.1.4. Мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг идэвхижүүлэх
- 4.1.5. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-mongolia системийг бүрэн нэвтрүүлэх
- 4.1.6. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах
- 4.1.7. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, архивын цаасан суурьтай баримтын цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулах

Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

Зорилт 4.2. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийн уялдааг хангах замаар үйлчилгээний үр дүн, нөлөөг дээшлүүлнэ.

- 4.2.1. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгох, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлэх
- 4.2.2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах
- 4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэх
- 4.2.4. “Стандарттай Увс” буюу чанарын удирдлагын тогтолцоо, олон улсын стандартыг төр, аж ахуйн нэгж байгууллагад ээлж дараагаар нэвтрүүлэх
- 4.2.5. Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтлах
- 4.2.6. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангах
- 4.2.7. Анхан шатны статистик мэдээний үнэн зөвд тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн нээлттэй ил тод байлгах нөхцлийг бүрдүүлэх, “дотоодын аялал жуулчлал”, “жендэрийн үзүүлэлт” зэрэг мэдээллийн баазыг шинээр үүсгэж түгээх
- 4.2.8. Аймгийн төр захиргааны зарим байгууллагын стандарт шаардлага хангасан байр оффис, парк шинэчлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэх

Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого

Зорилт 4.3. Хөрш болон бусад орнуудын эдийн засаг, нийгэм, соёлын уламжлалт хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж, чөлөөт худалдааг аймгийн онцлогт нийцүүлэн хөгжүүлнэ.

4.3.1. ОХУ болон БНХАУ-ыг холбосон эдийн засгийн коридорыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих хүрээнд ОХУ-ын Сибирийн тойргийн муж улсууд, БНХАУ-ын ШУӨЗО-ны аймгуудтай бүх салбарт харилцааг гүнзгийрүүлэх

4.3.2. Гадаадын өндөр хөгжилтэй гуравдагч хөрш орнуудын хот, мужуудтай шинээр харилцаа тогтоох, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд салбар бүрт төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Ухаалаг засаглал

Зорилт 4.4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлнэ.

4.4.1. Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд үүрэн холбоо, хэвлэл мэдээллийн болон цахим хэрэгслийг ашиглан, иргэн, хуулийн этгээд, иргэний нийгмийн болон өөрийн удирдлагын байгууллагуудтай хамтран, тэдгээрийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

4.4.2. Хууль сахиулах байгууллагуудын бие даасан байдлыг хангаж, материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Авлигагүй засаглал

4.4.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, соён гэгээрүүлэх ажлыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах

Зэвсэгт хүчин

Зорилт 4.5. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ:

4.5.1. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг бүх нийтэд сурталчилан таниулах,

4.5.2. "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэх

4.5.3. Аймгийн Цэргийн штабын албаны бэлэн байдлыг хангаж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, хилийн ангиудын үйл ажиллагааг дэмжих

4.5.4. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилэх

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

5.1.1. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалалтанд авах ажлыг нэмэгдүүлэх, усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэх

5.1.2. Аймаг, сумын төв, хөдөөгийн хүн амыг аюулгүй ус хангамжийн эх үүсвэрээр хангах, ундны усны чанарыг сайжруулах, ус хэрэглэгч, ашиглагчдын усны хэрэглээний хяналтыг сайжруулж, зохистой ашиглах механизмыг бүрдүүлэх

5.1.3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх, гангийн эрсдлийг бууруулах

5.1.4. Байгаль орчны төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, ажлын үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэх

5.2. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх

5.2.1. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг худалдан авах тогтолцоог бүрдүүлэх

5.2.2. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар бүх нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх, ухамсар дадлыг хэвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах

5.2.3. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байр, эмнэлгийг стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай болгох

5.2.4. Аймаг, сумын төвийн гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Жорлонгоо өөрчилье-Эко жорлон" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах

5.2.5. Улаангом сумын агаарын чанарыг дээшлүүлэх бүсийг тогтоож, бүсэд баримтлах дэглэмийг боловсруулан, хэрэгжүүлэх

5.3. Хариуцлагагай уул уурхайг дэмжиж, экологи, байгаль хамгааллын тогтвортой байдлыг хангах

5.3.1. Эвдэрсэн газрын тооллогыг хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд талуудын оролцоог хангах

5.3.2. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа арга хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх

5.4. Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд талуудын оролцоог хангаж, ойн нөөцийг нэмэгдүүлэх

5.4.1. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

5.4.2. Модны хэрэглээг багасгах, хорголон, үртсэн, шахмал түлш үйлдвэрлэх, импортоор орж ирэх мод, модон материалыг нэмэгдүүлэх

5.4.3. Аймгийн болон ой бүхий сумуудын ойн менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх

5.4.4. Салхи, газрын гүний дулааны эрчим хүчийг хэрэглээнд нэвтрүүлэхийг дэмжих

5.5. Амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх, ашиглалтын нөөцийг бүрдүүлэх

5.5.1. Амьтан, ургамлын тархац, нөөцийн судалгааг тогтмолжуулах, мэдээллийн санг бүрдүүлэх, хамгаалалт, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх

5.5.2. Амьтан, ургамлын нөөцийн ашиглалтыг ил тод болгож, нутгийн иргэдийн оролцоог хангах, байгалийн нөөцийн хамтын менежмент хэрэгжүүлэгч нөхөрлөлүүдийг чадавхижуулах

5.5.3. Зэрлэг ан амьтны амьдрах орчинг сайжруулах, биотехникийн арга хэмжээг зохион байгуулах

